



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/159

Цагаан-Уул сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 33 дугаар зүйлийн 33.1.1 Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны ээлжит XIV хуралдааны 09 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. 2024 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгасны дагуу 3057м² газрын хавсралтад дурдсанаар эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэдтэй эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгүүлэхийг газрын даамал (А.Энхбаатар), Улсын бүртгэгч (Д.Ичинхорлоо) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Сумын Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдснээс хойш 30 хоногийн дотор сумын Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулан актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг Газрын даамал (А.Энхбаатар)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ш.Эрдэнэцэцэг), Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Ч.Эрдэнэчулуун) нарт үүрэг болгосугай.

ДАРГА  С.ГОНЧИГНЯМ



/Zahiramj 2024/